

ЦАЛИН ХӨЛСГҮЙ АСРАХ АЖЛЫГ МӨНГӨН ДҮНГЭЭР ХЭМЖИХ НЬ

Гансүхийн Уран-Өлзий⁶ (МА), Худалдаа хөгжлийн банкны теллер

Хураангуй

Монгол Улсад цалин хөлсгүй асрах ажилд их хэмжээний хугацааг зарцуулж байгаа гэдгийг ҮСХ-оос олон удаагийн цаг ашиглалтын түүвэр судалгаагаар гаргасаар байна. Энэхүү судалгааны ажлаар ЦАС болон АХС-ны 2019 оны тоон өгөгдлийг ашиглан цалин хөлсгүй ажлын мөнгөн дүнг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төрийн үйлчилгээний цалин болон бүлгийн цалинг ашиглан хэмжихийг зорьсон. ЦАС 2019 онд нийт 6312 хүн өдрийн тэмдэглэл хөтөлсөн бөгөөд үүнээс 15-с дээш насны 6009 хүний тоон өгөгдлийг энэхүү судалгааны ажилдаа ашигласан болно.

Судалгааны үр дүнгээр 15-с дээш насны хүмүүсийн цалин хөлсгүй ажлын мөнгөн дүн нь ДНБ-ий 8.2-15.3 хувьтай тэнцүү байна. Үүнийг төрийн үйлчилгээний цалингийн доод түвшнээр хэмжвэл ДНБ-ний 11.5 хувь, хөдөлмөрийн хөлсний доод түвшнээр хэмжвэл ДНБ-ий 8.2 хувь, бүлгийн цалингаар хэмжвэл ДНБ-ий 15.3 хувьтай тэнцэхүйц байна. Бүлгийн цалингийн хувьд цалин хөлсгүй гэрийн ажил нь ДНБ-ий 5.4 хувь, цалин хөлсгүй асрах ажил нь ДНБ-ий 9.9 хувьтай тэнцэхүйц байна. Гэрийн ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5 дахин их цагийг, асрах ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс гурав дахин их хугацааг зарцуулж байна. Энэ нь цалин хөлсгүй ажилд хүйсийн өндөр ялгаа байгааг илтгэж байна. Цалин хөлсгүй ажил нь эдийн засагт их хэмжээний тооцогдоогүй нэмүү өртгийг бий болгож байгааг судалгаа харуулсан.

Түлхүүр үгс: Цалин хөлсгүй ажил, цалин хөлсгүй асрах ажил, цалин хөлсгүй гэрийн ажил

VALUING UNPAID CAREWORK

Abstract

A large amount of time is spent on unpaid care work in Mongolia, according to multiple time-use sample surveys by the National Statistics Office of Mongolia. Therefore, the monetary value of unpaid work was measured using the minimum wage, public service wages, and group wages based on the 2019 years Time Use Survey and the Labor Force Survey data. A total of 6,312 people kept diaries in 2019, of which numerical data of 6,009 people over the age of 15 were used for this study.

As a result of the research, the amount of unpaid work of people over 15 years of age is equal to 8.2-15.3 percent of GDP. It is equal to 11.5 percent of GDP if measured by the minimum wage level of public services, 8.2 percent of GDP if measured by the minimum wage level, and 15.3 percent of GDP if measured by group wages. In terms of group wages, unpaid housework is equivalent to 5.4 percent of GDP and unpaid care work is equivalent to 9.9 percent of GDP. Women spend 2.5 times more time than that of men on housework, and women's participation in caregiving is three times more than men. Consequently, there is a high gender gap in unpaid work. It has been measured that unpaid work creates a large amount of unaccounted value added to the economy.

Keywords: Unpaid work, unpaid care work, unpaid housework

1. ҮНДЭСЛЭЛ

Өрх гэр болон ажлын байран дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгаснаар Монгол Улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцооны түвшинг 63.2 хувь хүртэл өсгөх боломжтой гэж тооцоолжээ (АХБ, 2020). Хөдөлмөр эрхлэхийн хажуугаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад гурав дахин

илүү цагийг гэрийн ажил, өрхийн гишүүдийг асрахад зарцуулж байна (АХБ, 2020). Монгол Улсад цалин хөлсгүй асрах ажилд их хэмжээний хугацааг зарцуулж байгаа гэдгийг Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос олон удаагийн цаг ашиглалтын түүвэр судалгаагаар гаргасаар байна. Үүний үр

⁶ Холбоо барих зохиогч. Хаяг: Guujig9@gmail.com

дүнд цалин хөлсгүй ажлын ихэнх хувийг эмэгтэйчүүд хийж байгаа гэдэг нь тогтоогдсон. Жендэр судлаачдын үзэж байгаагаар энэ нь тодорхой эдийн засгийн, их хэмжээний тооцогдоогүй нэмүү өртгийг эдийн засагт бий болгодог. Тиймээс Монгол Улсын хувьд цалин хөлсгүй ажил эдийн засагт хэдий хэмжээний тооцогдоогүй нэмүү өртгийг шингээж байгааг тооцох нь чухал юм.

Энэ чиглэлийн судалгааны ажлуудаас дурдвал:

Jooyeoun Suh болон Elizabeth M. King(2021) бусад судлаачдын хамтарсан “Demographic, Health, and Economic Transitions and the Future Care Burden. Mongolia, Ghana, South Korea” судалгаанд Монгол, Өмнөд Солонгос, Гана улсын цалин хөлсгүй ажлыг мөнгөн дүнгээр хэмжсэн. Монгол Улсын хувьд 2015 оны *Цаг ашиглалтын судалгаа* (ЦАС)-г ашигласан ба үр дүнд нь 15-с дээш насны хүн амын цалин хөлсгүй ажилд зарцуулж буй нийт мөнгөн дүн 2015 оны ДНБ-ий 15-16 хувьтай тэнцэхүйц байна гэж тооцоолжээ.

Acharya (1991) Азийн хөгжиж буй орнуудад цалин хөлсгүй ажлыг мөнгөн дүнгээр хэмжсэн анхны судалгааг хийжээ. Судалгааны үр дүнд цалин хөлсгүй ажлын жилийн нийт мөнгөн дүн Балба улсын ДНБ-ий 46.6 хувьтай тэнцэж байсан ба үүний 93 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлжээ.

Бутан улсын хувьд ЦАС болон *Ажиллах хүчний судалгаа* (АХС)-ны 2015 оны мэдээллийг ашиглан хэмжихэд цалин хөлсгүй ажлын жилийн мөнгөн дүн бүлгийн цалингаар тооцвол ДНБ-ий 16 хувь, ерөнхий цалингаар тооцвол ДНБ-ий 10 хувьтай тэнцэхүйц байсан. (Jooyeoun Suh, Changa Dorji, 2020).

Шри Ланка улсын Үндэсний статистикийн хорооноос 2022 онд цалин хөлсгүй асрах ажлыг хэмжсэн бөгөөд одоогоор шинжилгээ нь албан ёсоор дуусаагүй байна (Dileni Gunewardena, 2022). Эхний шатны үр дүнгээс харахад цалин хөлсгүй асрах ажил нь ДНБ-ий 10.3-42 хувийн хооронд хэлбэлзэж байна. Өөрөөр хэлбэл, хэрэв цалин хөлсгүй асрах ажлыг ДНБ-д оруулсан бол доод хязгаарт ДНБ-ийг 10 хувиар, дээд хязгаарт 42 хувиар өсөх байсан. ДНБ-д оруулж тооцох доод хязгаарын 2 хувь, ДНБ-д оруулж тооцох дээд хязгаарын 8.3 хувийг л эрэгтэйчүүд бүрдүүлж байгаа ба үлдсэн хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа юм. Шри Ланка улсын статистикийн хороо энэхүү судалгаандаа Бутан улсад

хийгдсэн арга зүйг гол арга барилаа болгон ашигласан. Тиймээс энэ судалгааны ажилдаа Бутан улсад хийгдсэн орлуулалтын зардлын арга зүйг сонгосон. ЦАС 2019 болон АХС 2019 оны тоон өгөгдлүүдийг ашиглан цалин хөлсгүй асрах ажил нь ДНБ-д хэдий хэмжээний нэмүү өртгийг бий болгож болох байсныг тооцоолно. Үүнийг орлуулалтын зардлын аргаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төрийн үйлчилгээний цалин болон бүлгийн цалинг ашиглан хэмжинэ. Бутан улсад хийгдсэн судалгааны ажлын орлуулалтын зардлын арга зүйг сонгосон шалтгаан нь энэ улс Ази тивд харьяалагддаг, далайд гарцгүй, хүн ам багатай, жижиг улсын тоонд багтдаг зэрэг шинж чанараараа манай улстай төстэй байсан ба шинжилгээ нь хамгийн сүүлд хийж хэвлэгдсэн шинэлэг бүтээл юм.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгаагаар Монгол улс дахь цалин хөлсгүй асрах ажлыг мөнгөн дүнгээр хэмжиж ДНБ-д харьцуулах зорилгыг дэвшүүлсэн.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгаанд ашигласан тоон өгөгдөл

ЦАС-ны 2019 оны тоон мэдээлэл болон АХС-ны 2019 оны мэдээллийг шинжилгээнд ашигласан. Цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан 3972 өрхөд нийт 13627 хүн амьдарч байв. Судалгаанд хамрагдсан өрхөд 12 ба түүнээс дээш насны нийт 9820 хүн бүртгэгдсэнээс 6312 нь өдрийн тэмдэглэл хөтөлсөн байв. Тэднээс 15 ба түүнээс дээш насны 6009 хүний мэдээллийг энэ ажилд ашигласан. АХС-нд нийт 13280 өрхийн 44240 хүн хамрагдсан ба 15-64 насны 276176 хүний мэдээллийг ялган авч судалгаандаа ашигласан болно.


Мэдээлэл боловсруулалт ба дүн шинжилгээний аргачлал

Зах зээлийн цалингийн хэмжээг тогтооход ашигладаг хамгийн түгээмэл хоёр арга нь алдагдсан боломжийн зардал (*opportunity cost*) эсвэл орлуулах зардлын (*replacement cost*), арга юм (Абрахам ба Макки 2005). Орлуулах зардлын үнэлгээ нь тухайн хүний цалинтай ажлаас олсон орлогоос үл хамааран тодорхой ажил мэргэжлийн зах зээлийн ижил цалинг ашигладаг. Ерөнхий цалин нь ажлын шинж чанараас үл хамааран бүх үйл ажиллагаанд нэг цалин хуваарилдаг бол бүлгийн цалин

нь ажлын онцлогоос хамааран өөр өөр үйл ажиллагаанд өөр өөр цалин өгдөг. Цалин хөлсгүй ажлыг мөнгөн дүнгээр хэмжихдээ орцод суурилсан, орлуулах зардлын аргыг

ерөнхий цалин болон бүлгийн цалин гэсэн хоёр хувилбараар ашигласан. Аргачлалыг Зураг 2.1-д үзүүлэв.

Зураг 2.1 Цалин хөлсгүй асрах ажлыг мөнгөн дүнгээр хэмжих арга зүй



Эх үүсвэр: Jooyeoun Suh (2020).

15 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны хүмүүсийн цалин хөлсгүй асрах ажлын мөнгөн дүнг тооцохдоо дараах томъёог ашигласан (1).

$$V = \sum_{i=1}^N \sum_{j=1}^M P_i T_{ij} W_j \quad (1)$$

Энд,

V = Цалин хөлсгүй асрах ажлын жилийн мөнгөн дүн, N = Түүврийн хэмжээ, M = Цалин хөлсгүй ажлын үйл ажиллагааны тоо, P_i = Түүврийн жин, T_{ij} = 24 цагийн хугацаанд j -р бүлгээс цалин хөлсгүй ажилд зарцуулсан цагийн тоо, W_j = Үнэлгээний хувьд j бүлгийн нэг цагийн цалин, ерөнхий цалин эсвэл мэргэжилтний цалинг ашиглана.

Мэргэжилтний нэг цагийн цалингийн хэмжээг тодорхойлохын тулд Монгол Улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтын дагуу АХС 2019 оны тоон өгөгдлөөс мэргэжлийн бүлгүүдийн сарын орлогын мэдээллийг сар бүрийн ажлын цагаар хуваасан (Хүснэгт 2.1).

Ерөнхий цалингийн аргаар төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох төрийн үйлчилгээний ажилтан (ТҮ-1-1) цалин 451569 төгрөг дээр үндэслэсэн цалингийн хэмжээг ашигласан. Мөн хамгийн бага цалингийн аргаар тооцохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 320000 төгрөгөөр (2019 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ) тооцсон.

Хүснэгт 2.1 Нэг цагийн дундаж цалин /төгрөгөөр/, мэргэжлийн бүлгээр

Мэргэжил	1 цагийн дундаж цалин		Нийт цалин	Хариулагчдын тоо
	Дундаж	Голч		
Асрагч, сувилагч	3889.2	3409.1	692270	178
Бага ангийн багш	4425.7	3748.8	672699	152
Тогооч	2971.1	2613.6	808134	272
Хүүхэд асрагч	2741.9	2732.7	219351	80
Амьтан асрагч	1930.4	1166.7	13513	7
Гэрийн үйлчлэгч, цэвэрлэгч	2887.2	2306.8	1209728	419

Эх сурвалж: АХС 2019, судлаачийн тооцоолол


3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын хүн ам 2019 оны байдлаар дунджаар хоногийн 54 хувийг унтах болон хувийн үйл ажиллагаандаа, үлдсэн цагийг чөлөөт цаг, цалин хөлстэй ажил болон цалин хөлсгүй ажилд зарцуулдаг байна.

Хоногийн нийт 24 цагийг унтах, хувийн үйл

ажиллагаа, чөлөөт цаг, цалин хөлстэй ажил болон цалин хөлсгүй ажилд хуваахад унтах болон хувийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг хүйсийн хувьд ойролцоо байна (эрэгтэй-14.1 цаг; эмэгтэй-13.7 цаг). Хувийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс дунджаар 30 минутыг илүү зарцуулжээ (Зураг 3.1).

Зураг 3.1 Хувийн үйл ажиллагаа, унтахад зарцуулсан өдрийн дундаж цаг, хүйсээр




Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Эрэгтэйчүүд цалинтай ажилд илүү их цаг зарцуулсан бол эмэгтэйчүүд цалингүй ажилд илүү их цаг зарцуулж байгааг Зураг 3.2-т үзүүлэв. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад өдөрт дунджаар 144 минутыг цалинтай ажилд илүү зарцуулсан байна. Харин эмэгтэйчүүд 174 минут (2.9 цаг)-ыг

цалингүй ажилд илүү зарцуулсан бөгөөд үүнд гэрийн ажил болон асрах ажил багтаж байна. Чөлөөт цагаа өнгөрөөх байдал хүйсийн хувьд ялгаагүй байна. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд нэг өдрийнхөө 20 орчим хувийг гэрийн ажил, асрах ажилд зарцуулдаг бол эрэгтэйчүүд нэг өдрийнхөө 7.5 хувийг эдгээр үйл ажиллагаанд зарцуулдаг байна.

Зураг 3.2 Гол үйл ажиллагаанд зарцуулсан өдрийн дундаж цаг, хүйсээр




Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Эмэгтэйчүүд өдөрт дунджаар 216 минутыг гэрийн ажилд зарцуулж байсан бол эрэгтэйчүүд өдөрт дунджаар 86 минут буюу 2.5 дахин бага хугацааг зарцуулж байна (Зураг 3.3). Цалин хөлсгүй асрах ажлын хувьд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдээс бараг

гурав дахин их байна. Эмэгтэйчүүд өдөрт дунджаар 1 цагийг асрах ажилд зарцуулж байсан бол эрэгтэйчүүд өдөрт дунджаар 23 минутыг зарцуулсан. Энэ нь хүүхдээ харах, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах, өрхийн бусад гишүүдийг асрах ажлыг эмэгтэйчүүд голчлон гүйцэтгэж байгааг харуулж байна.

Зураг 3.3 Цалин хөлсгүй ажилд зарцуулсан өдрийн дундаж минут, хүйсээр




Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Хот, хөдөөгийн хувьд цалин хөлсгүй гэрийн ажилд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын ялгаа өндөр байна (Зураг 3.4). Хөдөө орон нутагт эмэгтэйчүүд өдөрт дунджаар 199 минутыг гэрийн ажилд зарцуулсан бол эрэгтэйчүүд үүнээс 14 дахин бага буюу 14 минутыг зарцуулж байна. Харин хотод эмэгтэйчүүд 235 минутыг, эрэгтэйчүүд 98 минутыг гэрийн ажилд зарцуулжээ. Хотод амьдардаг эмэгтэйчүүд хөдөө амьдардаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад гэрийн ажилд их цаг зарцуулж байна. Энэ нь хөдөө орон

нутгийн эмэгтэйчүүд гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн болон холбогдох албан бус үйл ажиллагаанд илүү их цаг зарцуулдагтай холбоотой байж болох юм. Асрах ажлын хувьд хотод амьдардаг хүмүүс хөдөөгийн хүмүүстэй харьцуулахад 2 дахин бага хугацаа зарцуулж байгаа хэдий ч хүйсийн хувьд хоорондоо ялгаагүй байна. Хөдөө амьдардаг хүмүүс өдөрт дунджаар 155 минутыг асрах ажилд зарцуулж байхад хотод амьдардаг хүмүүс өдөрт дунджаар 82 минутыг зарцуулжээ.

Зураг 3.4 Цалин хөлсгүй ажилд зарцуулсан өдрийн дундаж минут, байршлаар, хүйсээр




Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

Ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран эмэгтэйчүүдийн өдөр тутмын цалин хөлсгүй гэрийнажилд зарцуулдаг цаг нь эрэгтэйчүүдээс илүү байна (Зураг 3.5). Ажилгүй хүмүүс ажил хийдэг хүмүүстэй харьцуулахад хүйсээс үл хамааран 2 дахин илүү цагийг цалин хөлсгүй

гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан. Харин асрах ажлын хувьд ажил хийдэг хүмүүсд хүйсийн ялгаа байхгүй байна. Ажил хийдэггүй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 14 минутаар илүү цагийг асрах ажилд зарцуулжээ.

Зураг 3.5 Цалин хөлсгүй ажилд зарцуулсан өдрийн дундаж минут, ажил эрхлэлтээр, хүйсээр



Эх сурвалж: ЦАС 2019, судлаачийн тооцоолол

2019 оны байдлаар нэрлэсэн ДНБ 37.8 их наяд төгрөг байна. Цалин хөлсгүй ажлыг мэргэжилтний цалингийн арга ашиглан мөнгөн дүнгээр хэмжин *Хүснэгт 3.1*-д харуулав. Цалин хөлсгүй ажлын жилийн мөнгөн дүн 5.7

их наяд төгрөг байгаа ба энэ нь ДНБ-ий 15.3 хувьтай тэнцүү байна. Үүнээс цалин хөлсгүй гэрийн ажил нь 5.4 хувь байгаа бол цалин хөлсгүй асрах ажил нь ДНБ-ий 9.9 хувьтай тэнцэхүйц байна.

Хүснэгт 3.1 Цалин хөлсгүй ажлын ДНБ-д эзлэх хувь

Гүйцэтгэсэн ажил	1 цагийн дундаж мэргэжилтний цалин	Тухайн ажлыг хийсэн хүн тоо	Нийт хүн амд эзлэх хувийн жин (%)		1 өдөрт зарцуулсан нийт цаг	1 жилд зарцуулсан нийт цалин, сая төгрөгөөр	ДНБ-д эзлэх хувь
			Эрэгтэй	Эмэгтэй			
Хоол хийх	2971.1	4452	21.0	53.0	813133.8	881798.07	2.3
Гэрийн цэвэрлэгээ, бусад	2887.2	6009	43.0	57.0	1095639	1154606.05	3.1
Амьтан асрах	1930.4	181	1.0	2.0	33011.69	23260.22	0.1
Хүүхэд асрах	2741.9	2123	9.0	26.0	387844.6	388149.73	1.0
Хүүхдэд заах	4425.7	721	3.0	9.0	131782.9	212877.31	0.6
Өвчтэй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	3889.2	6009	43.0	57.0	1095639	1555305.72	4.1
Өрхийн бусад хүн асрах	3889.2	6009	43.0	57.0	1095639	1555305.72	4.1
Нийт						5771302.86	15.3%


Тэмдэглэл: Төрийн үйлчилгээний ажилтны цалингаар (ТҮ-1-1) тооцвол, цалин хөлсгүй ажлын жилийн мөнгөн дүн 4.3 их наяд төгрөг байгаа ба энэ нь ДНБ-ий 11.5 хувьтай тэнцүү байна. Үүнээс цалин хөлсгүй гэрийн ажил 4.7 хувь, цалин хөлсгүй асрах ажил ДНБ-ий 6.8 хувьтай тэнцэхүйц байна.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Харин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу сарын 320000 төгрөгөөр тооцвол цалин хөлсгүй ажил ДНБ-ий 8.16 хувьтай тэнцэхүйц байна. Үүнээс, цалин хөлсгүй асрах ажил ДНБ-ий 4.9 хувьтай тэнцэхүйц байна (Зураг 3.7).


ДНБ салбараар авч үзвэл, 2019 онд хамгийн өндөр хувийг уул уурхай, олборлолт (25.3%) эзэлж байна (Зураг 3.8). Харин цалин хөлсгүй асрах ажлыг харьцуулж үзвэл 9.9 хувийг бүрдүүлж дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна. Энэ нь цалин хөлсгүй асрах ажлыг мөнгөн дүнгээр хэмжиж ДНБ-д оруулах нь маш чухал гэдгийг илтгэж байна.

Зураг 3.7 Цалин хөлсгүй ажлын ДНБ-д эзлэх хувь, цалингийн төрлөөр



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Зураг 3.8 Дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, салбараар, 2019



Эх сурвалж: ҮСХ 2019

4. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар 2019 оны “Цаг ашиглалтын судалгаа”-наас 15 ба түүнээс дээш насны 6009 хүний тоон мэдээлэл болон “Ажиллах хүчний судалгаа”-ны өгөгдлийг ашиглан цалин хөлсгүй ажлыг мөнгөн дүнгээр хэмжсэн. Цалин хөлсгүй ажилд гэрийн ажил болон асрах ажлыг багтаасан болно.

- Судалгааны үр дүнгээс харахад мэргэжлийн цалингийн хувьд 15 ба түүнээс дээш насны цалин хөлсгүй ажлын нийт мөнгөн дүн 5.7 их наяд төгрөг байгаа ба энэ нь ДНБ-ий 15.3 хувьтай тэнцүү байна. Үүнээс цалин хөлсгүй гэрийн ажил 5.4 хувь, цалин хөлсгүй асрах ажил ДНБ-ий 9.9 хувьтай тэнцэхүйц байна. Энэ нь бусад улс оронд хийгдсэн судлаачдын үр дүнтэй нийцтэй байна.
- Ерөнхий цалингийн аргаар тооцвол цалин хөлсгүй ажил ДНБ-ий 8.2-11.5 хувьтай тэнцэхүйц байна. Гэрийн ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5 дахин их хугацааг зарцуулж байна. Мөн цалин хөлсгүй асрах ажлын хувьд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдээс гурав дахин их байна.
- Үүнээс дүгнэхэд цалин хөлсгүй ажилд хүйсийн өндөр ялгаа харагдаж байгаа ба энэ нь хэмжигдээгүй их хэмжээний нэмүү өртгийг эдийн засагт бий болгож байна.
- Энэхүү судалгаанд хамрагдсан цалин хөлсгүй хөдөлмөрийн үнэ цэнийн тооцоог 24 цагийн туршид хүмүүсийн хийдэг үндсэн үйл ажиллагаанд үндэслэн цаг ашиглалтын хэмжүүрээс гаргаж авсан болно. Гэсэн хэдий ч хүүхэд асрах зэрэг үйл ажиллагаа нь ихэвчлэн бусад үйл ажиллагаатай зэрэг явагддаг бөгөөд эдгээр нэгэн зэрэг үйл ажиллагаа нь бидний судалгааны тооцоолсон тооцоонд ороогүй.
- Энэ судалгааны ажил 2019 оны тоон өгөгдлийг ашигласан бөгөөд энэ нь Ковидоос өмнөх тоон мэдээлэл юм. Тиймээс цаашид энэхүү ажлыг ашиглан тоон мэдээллийг шинэчлэн илүү нарийвчлалтай, дэлгэрэнгүй судалгаа хийх хэрэгтэй байна. Эдийн засагт ийм их хэмжээний тооцогдоогүй нэмүү өртөг гарч байгаад бодлого боловсруулагчид анхаарал хандуулах шаардлагатай. Цаашлаад цалин хөлсгүй ажилд хүйсийн ялгаатай байдлыг багасгаснаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол хэлээр:

Азийн Хөгжлийн Банк, 2020. Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр МУ-н урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь.

Г.Цэвээндолгор, 2021. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын үзүүлэх нөлөөг хэмжих нь.

Монгол улсын засгийн газрын тогтоол, 2019. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэх тогтоох тухай.

ҮСХ, 2019. Ажиллах хүчний судалгааны тайлан. *Статистикийн үндэсний хороо, Улаанбаатар*

ҮСХ, 2019. *Цаг ашиглалтын судалгааны тайлан. Статистикийн үндэсний хороо, Улаанбаатар*

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурвал талт үндэсний хорооны тогтоол. (2019). Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай.

Англи хэл дээр:

M.Acharya, 1993. The Household Economy and Women’s Work in Nepal. In Saraswati Raju and Deipica Bagchi, eds. *Women and Work in South Asia: Regional Patterns and Perspectives*.

Dilani Gunewardena, 2022. *Valuing Unpaid Care Work in Sri Lanka Using the National Time Use Survey 2017: First Estimates*.

Elizabeth M. King, Hannah L. Randolph, Maria S. Floro, Jooyeoun Suh, 2021. Demographic, health, and economic transitions and the future care burden. *Mongolia, Ghana, South Korea*.

Jooyeoun Suh, Changa Dorji, Valerie Mercer-Blackman, and Aimee Hampel-Milagrosa, 2020. *ADB Economics Working Paper Series: Valuing Unpaid Care Work in Bhutan*.

Suh, Jooyeoun, and Nancy Folbre, 2016. *Valuing Unpaid Child Care in the U.S.: A Prototype Satellite Account Using the American Time Use Survey*.